

1. Монголчууд XVII-XX зууны эхэн үе хүртэл ямар улсын эрхшээлд байсан бэ?

- A. Түрэг улс
 B. Манж Чин улс
 C. Хятад улс
 D. Хаант Орос улс

2. Манж нар ямар угсаатан бэ?

- A. Зүрчид
 B. Хятад
 C. Түрэг
 D. Монгол

3. 1771 онд Увш ханы удирдлага дор Халимагууд Зүүнгарын нутаг руу их нүүдэл хийв. Уг үйл явдлыг билгийн тоололд шилжүүлнэ үү.

Доорх өгөгдлийг ашиглаж бодоорой.

Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга	Махбод Жил	Гал	Шороо	Төмөр	Ус	Мод
Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хас ч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ноогдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүний махбодыг олно.	Туулай	1	13	25	37	49
	Луу	50	2	14	26	38
	Могой	51	3	15	27	39
	Морь	40	52	4	16	28
	Хонь	41	53	5	17	29
	Бич	30	42	54	6	18
	Тахиа	31	43	55	7	19
	Нохой	20	32	44	56	8
	Гахай	21	33	45	57	9
	Хулгана	10	22	34	46	58
	Үхэр	11	23	35	47	59
	Бар	60	12	24	36	48

- A. XII жарны төмөр туулай жил
 B. XIII жарны төмөр туулай жил
 C. XII жарны гал хонь жил
 D. XIII жарны гал хонь жил

4. Сурвалжид “Зургаан түмний эзэн” гэж хэнийг хэлсэн бэ?

Сурвалж-1: “...Бичиг барихын учир: Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидэн...хас их төрийг хадгалж суунам бид. Энэ их төрийг санахул нь нааш цааш элч юугаан тасралтгүй [илгээн] мэнд асуулцаж явъя.”

Халхын ноёдоос Манжийн хаанд илгээсэн бичгээс.

- A. Занабазар
 B. Абахай
 C. Лигдэн хаан
 D. Галдан


5. XVII зууны эхээр Хөх нуурт байгуулагдсан улс аль вэ?

- A. Халимаг
 B. Хотгойд
 C. Хошууд
 D. Цорос

6. Өвөр Монгол манжид хэзээ дагаар орсон бэ?

- A. 1636 он
 B. 1691 он
 C. 1721 он
 D. 1755 он

7. Он тооллын шугамд тэмдэглэгдсэн үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?



A. 304

B. 270

C. 389

D. 334

8. Сурвалжид хэзээ, хаана болсон ямар үйл тухай бичсэн байна вэ?

Сурвалж-2: "...Чингүнжав оргосон Урианхайг нэхэж Хөх усны зэрэг газарт хүрээд цаашаа давшиж орсонгүй дур мэдэн цэргээ авч хойш буцсан бөгөөд түүний айлтгасан нь: Олон халхчууд гаслалдан хэлэлцэнэ. Бас Амарсанааг барихад дэмий л олныг зовоож улсын цалинг ашиггүй сүйтгэнэ. Цэргийг бүрмөсөн татаж өөлд нарыг уг нутагт илгээж, олон амьтныг жаргааваас зохино. Хэрэв удтал явсаар нэгэн хэрэг гарч ирвэл улсын нэрд холбогдсон явдал буй гэж огоот дайлсан, тэрсэлсэн адил дэмий хэлэлцжээ ...энэ ангид угаас Урианхай цэрэг 500, Хотгойд цэрэг 250, Халх цэрэг 100 илүү, бүгд 800 илүү цэрэг байв."

Хэрэг шийтгэх сайд Шүмин, Арантай нараас Манжийн хаанд айлтгасан айлтгалаас.

A. 1755-1758 оны Баруун Монгол дахь тусгаар тогтнолын тэмцэл, хөдөлгөөний тухай


B. 1755-1758 оны Халх Монгол дахь тусгаар тогтнолын тэмцэл, хөдөлгөөний тухай

C. 1755-1758 оны Өвөр Монгол дахь тусгаар тогтнолын тэмцэл, хөдөлгөөний тухай

D. 1900 он Улиастайд гарсан 2000 цэргийн бослого, хөдөлгөөний тухай

9. 12-р сарын 29-ний өдрийн яг ёслол болсон цаг мөчид Ховд, Улиастай, Алтанбулаг, Ерөө зэрэг олон газар, Монголын өнцөг булан бүрт хүмүүс Хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясчээ. Үүнийг биеэр үзсэн гадаадынхан олон Монголчуудын нүд урьд өмнө хэзээ ч ингэж очтон гэрэлтэж байсныг хараагүй хэмээн бичсэн байдаг.

Мэдээлэлд гарч буй "Ховд хот"-ыг газар зүйн зурагт ямар үсгээр тэмдэглэсэн байна вэ?



A. "Б" үсэг

B. "А" үсэг

C. "В" үсэг

D. "Г" үсэг

10. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есний өдөр аргын тооллоор хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

A. 1924.11.26

B. 1945.10.20

C. 1911.12.29

D. 1992.01.13

11. 1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаад "нийслэл"-ээ хэрхэн нэрлэсэн бэ?

A. Улаанбаатар

B. Хүрээ

C. Нийслэл Хүрээ

D. Өргөө

12. Олноо өргөгдсний 8-р оноос “Зарлигаар тогтоосон МУ-ын шаштир” гэх 12 дэвтэр түүхийн бүтээл гарчээ. Уг үйл явдал аргын тооллын хэдэн онд болсныг тооцоолно уу.

- A. 1917 он B. 18 он C. 8 он D. 1918 он

13. Гадаад Монголын автономит эрхийг халсныг зарлах ёслол хэзээ болсон бэ?

- A. 1915.06.07 B. 1913.11.08 C. 1912.11.03 D. 1920.01.02

14. Консулын дэнжийн бүлгэмийг үндэслэгч хэн бэ?

- A. М.Ханддорж B. С.Данзан C. VIII Богд Жавзандамба D. Д.Бодоо

15. Эх сурвалжийг уншиж асуултад хариулна уу.

Хувьсгалчид “МАН” гэх модон тамга хэрэглэж байсны дээр хоорондоо харилцахдаа 400-аад үгтэй нууц түлхүүр ашиглаж байжээ. Жишээлбэл: “Малын үнэ муу. Хээр морь эмгээгтэй. Бутковоос янчаан авах төлөвтэй. Георгийгоор хүргүүлнэ. Мөнгөний явдалд яар, хариу даруй өг. Иван”.

Үндэсний Төв архиваас. (Ц.Гантулга нар. Монголын түүх XI. УБ., 2017. т. 26)

- Сурвалжид дурдагдаж “Иван” гэж хэн бэ?

- A. Сюй Шүжан B. Д.Бодоо C. Д.Догсом D. VIII Богд Жавзандамба

16. ...“1932 оны дунд үе хүртэл үргэлжилсэн энэхүү дүрвэх хөдөлгөөнд БНМАУ-ын хилийн дагуу орших засаг захиргааны одоогийн Ховд, Баян-өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгууд хамрагдсан байна. Эндээс үзвэл хил даван дүрвэх явдал хил залгаа бараг бүх аймгийг хамарсан хөдөлгөөний хэлбэртэй байжээ. Дүрвэгсдийн дотор лам, хар феодал агсад, нам, эвлэлийн гишүүд хүртэл оролцсон байв. Бүрэн бус мэдээгээр нийтдээ 7542 өрх айл буюу дунджаар 30 мянга гаруй хүн дүрвэсэн нь мэдэгдэж байна”...


Дээрх мэдээнд дурдагдаж буй дүрвэх хөдөлгөөн төрийн ямар бодлоготой уялдан гарсан бэ?

- A. Баруунтны алдаатай бодлого үйл ажиллагаанаас шалтгаалсан
 B. Мал сүргийн бэлчээр хомсдож байснаас шалтгаалсан
 C. Японы эзэнт улс Монгол улстай дайн заралсанаас шалтгаалсан
 D. Зүүнтний алдаатай бодлого үйл ажиллагаанаас шалтгаалсан

17. 1945 оны Чөлөөлөх дайнд баатарлаг гавьяа байгуулж, БНМАУ-ын баатар цолоор шагнагдагсдыг сонгоно уу.

- A. Д.Данзанваанчиг, Д.Гуулин, Ж.Гонгор
 B. Л.Дандар, Ц.Олзвой, С.Дампил, Х.Дамба
 C. Х.Дамба, Ж.Нэхийт, Л.Жанчив, Л.Аюуш
 D. Л.Дандар, Ц.Олзвой, П.Чогдон, Л.Гэлэгбаатар

18. Завхан аймгийн Дөрвөлжин сумын малчин Б.Дорлиг ЗХУ-ын армид 1942 онд 2500 төгрөг, 137 адуу бэлэглэжээ. Уг малчны нутгийг газар зүйн зурагт заана уу.



- A. 3
 B. 4
 C. 2
 D. 1

19. БНМАУ-д айлчилсан ЗХУ-ын удирдагчийг сонгоно уу.

- A. В.И.Ленин B. Н.С.Хрущев C. Барон Унгерн D. В.Путин

20. Монгол улс Нэгдсэн Үндэсний байгууллагад хэзээ гишүүнээр элссэн бэ?

- A. 1911 оны 12 сарын 29 B. 1992 оны 01 сарын 13
C. 1961 оны 10 сарын 27 D. 1924 оны 11 сарын 26

21. Монголын Ардчилсан холбоо (МоАХ)-ны анхны зохицуулагч хэн бэ?

- A. Э.Бат-Үүл B. Р.Амаржаргал C. Ц.Элбэгдорж D. С.Зориг

22. Монголын түүхэн дэх анхны чөлөөт ардчилсан сонгуулиар Ардын Их Хурлын депутатад хамгийн олон суудал авсан нам аль вэ?

- A. МАХН B. МСДН C. МоАХ D. МНН

23. Он тооллыг шугамыг ашиглан асуултад хариулна уу.



- A. Р.Гончигдорж B. Д.Бямбасүрэн C. Ц.Лоохууз D. П.Очирбат

24. 1990 онд Монголд ардчилсан хувьсгал гарахад нөлөөлсөн дотоод шалтгааныг тодорхойлно уу.

- A. БНМАУ-д социалист байгуулалт мухардалд орж улс төр, нийгэм, эдийн засагт хямрал нүүрлэснээс
B. БНМАУ-д нийгэм дэх хөрөнгө чинээний ялгаа их болсноос
C. БНМАУ-д хөрөнгөтөн орнуудын үзэл суртал, соёл нэвтэрснээс
D. БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга, СНЗ-ийн дарга асан Ю.Цэдэнбал нас барсна

25. Эх сурвалжийг уншиж, асуултад хариулна уу.

“Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, ...эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчидсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”.

Монгол Улсын Үндсэн хуулиас.

- Хэзээ батлагдсан Үндсэн хуулийн зорилго болохыг тодорхойлно уу.

- A. 1924 оны 11 сарын 26 B. 1940 оны 06 сарын 30
C. 1992 оны 01 сарын 13 D. 1960 оны 07 сарын 06